



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/165/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022. 02.16 № 2/16

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

• 005020?18

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,196,424.00</u>	<u>10,037,024.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	12,196,424.00	10,037,024.00
354	Хангамжийн материал	12,196,424.00	10,037,024.00
35410	Бичиг хэргийн материал	2,837,500.00	865,000.00
35420	Аж ахуйн материал	9,358,924.00	9,172,024.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>229,422,876.62</u>	<u>226,950,258.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	229,422,876.62	226,950,258.15
392	Биет хөрөнгө	205,422,876.62	209,450,258.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	145,772,177.00	145,772,177.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-10,311,741.12	-15,467,611.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,951,649.07	57,568,276.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,485,528.74	-13,308,822.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,835,346.00	74,466,333.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,339,025.59	-39,580,093.96
393	Биет бус хөрөнгө	24,000,000.00	17,500,000.00
39301	Програм хангамж	7,655,000.00	7,655,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,155,000.00	-7,655,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,500,000.00	17,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>241,619,300.62</u>	<u>236,987,282.15</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>241,619,300.62</u>	<u>236,987,282.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	241,619,300.62	236,987,282.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,454,481,459.57	1,454,481,459.57
51101	Өмч: - төрийн	1,454,481,459.57	1,454,481,459.57
512	Хуримтлагдсан үр дүн	-1,256,842,723.52	-1,261,474,741.99
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,256,842,723.52	-1,256,842,723.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,632,018.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,980,564.57	43,980,564.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>241,619,300.62</u>	<u>236,987,282.15</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	840,266,140.00	840,272,647.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,260,040.00	27,693,947.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,260,040.00	27,693,947.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	802,006,100.00	812,578,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	755,361,100.00	796,343,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	755,361,100.00	796,343,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,645,000.00	16,235,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,645,000.00	00.00

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,000,000.00	15,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	735,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	826,788,631.93	844,904,665.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	826,788,631.93	844,904,665.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,177,394.91	787,447,478.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	599,867,638.00	591,438,165.00
210101	Үндсэн цалин	541,307,987.00	418,333,624.00
210102	Нэмэгдэл	54,547,151.00	160,002,041.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,012,500.00	13,102,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,923,933.98	77,254,095.73
210201	Тэтгэврийн даатгал	50,569,198.00	54,014,113.42
210202	Тэтгэмжийн даатгал	6,037,350.00	5,430,124.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,848,150.00	4,806,129.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,133,096.00	1,111,368.67
210205	Эрүүл мэндийн даатгал	11,336,139.98	11,892,360.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,018,954.00	57,140,794.91
210301	Гэрэл, цахилгаан	3,771,758.00	4,189,314.91
210302	Түлш, халаалт	47,969,460.00	51,167,424.00
210303	Цэвэр, бохир ус	2,277,736.00	1,784,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,954,177.00	9,463,097.46
210401	Бичиг хэрэг	2,337,900.00	3,409,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,046,500.00	1,951,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,625,977.00	2,883,547.46
210404	Ном, хэвлэл	00.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	158,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	785,800.00	1,173,600.00
2105	Нормативт зардал	192,000.00	368,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	192,000.00	368,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,322,500.00	1,450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	280,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,042,500.00	1,450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,473,660.00	19,831,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,052,500.00	17,514,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	1,130,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	295,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	77,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,000.00	559,500.00
210807	Газрын төлбөр	317,660.00	317,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,424,531.93	30,501,665.47
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,424,531.93	30,501,665.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,611,237.02	57,457,186.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,055,000.00	54,093,981.78
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	53,224,981.78
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,055,000.00	869,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,556,237.02	3,363,205.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,556,237.02	3,361,705.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,477,508.07	-4,632,018.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	802,006,100.00	812,578,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	802,006,100.00	812,578,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	755,361,100.00	796,343,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	755,361,100.00	796,343,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,645,000.00	16,235,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	700,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,000,000.00	15,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	945,000.00	735,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	800,086,100.00	812,159,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	800,086,100.00	812,159,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	784,474,862.98	754,702,313.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	599,867,638.00	591,438,165.00
210101	Үндсэн цалин	541,307,987.00	418,333,624.00
210102	Нэмэгдэл	54,547,151.00	160,002,041.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,012,500.00	13,102,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,923,933.98	77,254,095.73
210201	Тэтгэврийн даатгал	50,421,404.49	54,014,113.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,922,807.75	5,430,124.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,743,010.36	4,806,129.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,166,976.70	1,111,368.67
210205	Эрүүл мэндийн даатгал	11,669,734.68	11,892,360.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,018,954.00	57,140,794.91
210301	Гэрэл, цахилгаан	3,771,758.00	4,189,314.91
210302	Түлш, халаалт	47,969,460.00	51,167,424.00
210303	Цэвэр, бохир ус	2,277,736.00	1,784,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,954,177.00	8,713,097.46
210401	Бичиг хэрэг	2,337,900.00	2,659,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,046,500.00	1,951,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,625,977.00	2,883,547.46
210404	Ном, хэвлэл	00.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	158,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	785,800.00	1,173,600.00
2105	Нормативт зардал	192,000.00	155,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	192,000.00	155,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,372,000.00	1,450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	329,500.00	00.00
210604	Урсгал засвар	1,042,500.00	1,450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,146,160.00	18,551,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,725,000.00	16,233,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	1,130,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	295,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	77,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	398,000.00	559,500.00
210807	Газрын төлбөр	317,660.00	317,660.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,611,237.02	57,457,186.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,055,000.00	54,093,981.78
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	53,224,981.78
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,055,000.00	869,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,556,237.02	3,363,205.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,556,237.02	3,361,705.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,920,000.00</u>	<u>419,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,920,000.00	419,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,920,000.00	419,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,920,000.00	419,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,920,000.00	419,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,920,000.00</u>	<u>-419,200.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,270,320,231.59	00.00	228,141,792.55
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,270,320,231.59	00.00	228,141,792.55
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,216,008.07	00.00	11,216,008.07
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,256,842,723.52	00.00	241,619,300.62
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,256,842,723.52	00.00	241,619,300.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,256,842,723.52	00.00	241,619,300.62

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,632,018.47	00.00	-4,632,018.47
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,261,474,741.99	00.00	236,987,282.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	796,343,700.00	792,981,994.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	796,343,700.00	792,981,994.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,249,500.00	738,888,013.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,454,500.00	591,438,165.00
210101	Үндсэн цалин	447,339,600.00	418,333,624.00
210102	Нэмэгдэл	124,875,900.00	160,002,041.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,239,000.00	13,102,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,846,300.00	77,254,095.73
210201	Тэтгэврийн даатгал	56,188,200.00	54,014,113.42
210202	Тэтгэмжийн даатгал	5,914,500.00	5,430,124.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,731,600.00	4,806,129.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,182,900.00	1,111,368.67
210205	Эрүүл мэндийн даатгал	11,829,100.00	11,892,360.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,866,400.00	57,140,794.91
210301	Гэрэл, цахилгаан	4,577,400.00	4,189,314.91
210302	Түлш, халаалт	51,236,500.00	51,167,424.00
210303	Цэвэр, бохир ус	2,052,500.00	1,784,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,716,100.00	8,713,097.46
210401	Бичиг хэрэг	2,661,300.00	2,659,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,228,800.00	1,951,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,513,700.00	2,883,547.46
210404	Ном, хэвлэл	00.00	45,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	138,700.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,173,600.00	1,173,600.00
2105	Нормативт зардал	155,700.00	155,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	155,700.00	155,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,869,200.00	1,869,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	419,200.00	419,200.00
210604	Урсгал засвар	1,450,000.00	1,450,000.00

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,341,300.00	2,317,660.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,130,000.00	1,130,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,700.00	77,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,600.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	571,400.00	559,500.00
210807	Газрын төлбөр	327,600.00	317,660.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54094200.00	54093981.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,094,200.00	54,093,981.78
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,225,000.00	53,224,981.78
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	869,200.00	869,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	796,343,700.00	792,981,994.88
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	796,343,700.00	792,981,994.88
131001	Улсын төсвөөс санхүүжих	796,343,700.00	792,981,994.88
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	53.00	53.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	45.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,645,000.00	16,233,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,645,000.00	16,233,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,645,000.00	16,233,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46645000.00	16,233,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46645000.00	16,233,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	46,645,000.00	16,235,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,645,000.00	16,235,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	700,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,000,000.00	15,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	945,000.00	735,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 1/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Баянхонгор аймгийн хэмжээнд нийгмийн халамж, хамгааллын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан, нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөр, төлөвлөлтөд нийцсэн мэдээллийн бодит бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ХХҮЕГ-аас дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 826,788.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,267.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,787.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 5,914.3 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн..

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,632.0 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,196.4	10,037.0	(2,159.4)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	12,196.4	10,037.0	(2,159.4)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	229,422.9	226,950.3	(2,472.6)
Үндсэн хөрөнгө	378,714.2	302,961.8	(75,752.4)
Хуримтлагдсан элэгдэл	(149,291.3)	(76,011.5)	73,279.8
Нийт хөрөнгө	241,619.3	236,987.3	(4,632.0)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	241,619.3	236,987.3	(4,632.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	241,619.3	236,987.3	(4,632.0)



Бараа материалын дансны үлдэгдэл 10,037.0 мянган төгрөг болж 2,159.0 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1,972.5 төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 302,976.8 мянган төгрөг болж 75,752.4 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 722 тоот тогтоолоор 103781,4 мянган төгрөгийн хөрөнгө акталсан бөгөөд дээд шатны төсөв захирагчаас 28,029.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 236,987.3 мянган төгрөг болж 4,632.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн 4,632.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 862,850.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 862,850.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 66,506.4 мянган төгрөгөөр бууруулж 796,343.7 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 796,343.7 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 796,343.7 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 792,982.0 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 3,361.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 792,982.0 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөн нийгмийн даатгалын шимтгэл 2592.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 725.6 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 15,500.0 мянган төгрөгийг олгосон бөгөөд тухайн санхүүжилтийг өрхийн судалгаа хийх зориулалтаар ирснийг зарцуулсан бөгөөд оны эцэст 1.5 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Тухайн байгууллагад ажиллаж байсан 2 мэргэжилтэн өндөр насны тэтгэвэр тогтоолгож 2021 оны 12 дугаар сарын 31-нд тасалбар болгон чөлөөлөгдсөн байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт хөдөлмөр эрхлэлтийн 3 арга хэмжээний 12 зорилт, нийгмийн халамжийн бодлогын 2 арга хэмжээний 12 зорилт, гэх мэт бусад арга хэмжээнүүдийг зорилт болгох оны эцэст ХХҮЕГ-т 97.9 хувьтай биелэлт гарган хүргүүлсэн боловч аудит хийх хугацаанд дүгнэгдэж ирээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 844,904.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 18,116.1 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон халаалт, тэтгэмжийн зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 906,614.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	96	0	0
6	Нийт	27	151	149	0	2

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Тайлант онд 796,343.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 792,982.0 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 3,361.7 мянган төгрөг буюу төсвийн 0.4 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____ оОо _____

